

**АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ  
АСУУДЛЫН ДЭД ХОРООНЫ  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**  
*2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр, Лхагва гараг*

<i>Хуралдааны тэмдэглэлийн агуулга</i>	<i>0</i>
<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-2</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>3-15</i>
<hr/>	
<i>1. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны төлөвлөгөө болон сайжруулсан шахмал түлшний чанар, эрсдэлийн талаар цаг үеийн мэдээлэл сонсох</i>	<i>3-15</i>

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы  
Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны  
2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр /Лхагва гараг/-ийн  
хуралдааны товч тэмдэглэл**

Агаарын бохирдлыг бууруулах асуудлын дэд хорооны дарга Г.Ганболд ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 14 цаг 12 минутад Төрийн ордны “Их эзэн Чингис хаан” танхимд эхлэв.

Томилолттой: Т.Аубакир, Ц.Туваан.

Хэлэлцэх асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням үг хэлэв.

**Нэг.Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны төлөвлөгөө болон сайжруулсан шахмал түлшний чанар, эрсдэлийн талаар цаг үеийн мэдээлэл сонсох**

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга Б.Насантогтох, Түлшний бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга И.Лувсанцэрэн, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Х.Энхбат, мөн хорооны Үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн Ж.Амгаланбаяр, Агаарын чанар хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Оюунчимэг, Хөрс, ус, хог хаягдлын менежмент хариуцсан ахлах мэргэжилтэн Э.Ерөөлт нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Ш.Ариунжаргал, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн референт Ц.Рэнцэнтогтох нар байлцав.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны төлөвлөгөө болон сайжруулсан шахмал түлшний чанар, эрсдэлийн талаар цаг үеийн мэдээллийг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Х.Энхбат хийв.

Мэдээлэлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Г.Дамдинням, Г.Ганболд нарын тавьсан асуултад Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд Ажлын албаны дарга Х.Энхбат, мөн хорооны Агаарын чанар хариуцсан ахлах мэргэжилтэн Б.Оюунчимэг нар хариулж, тайлбар хийв.

Дэд хорооны дарга Г.Ганболд үг хэлэв.

Улсын Их Хурлын гишүүд Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны төлөвлөгөө болон сайжруулсан шахмал түлшний чанар, эрсдэлийн талаар цаг үеийн мэдээлэл сонслоо.

*Уг асуудлыг 14 цаг 58 минутад хэлэлцэж дуусав.*

Дэд хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

*Хуралдаан 47 минут үргэлжилж, 5 гишүүнээс 3 гишүүн хүрэлцэн ирж, 60.0 хувийн ирцтэйгээр 14 цаг 59 минутад өндөрлөв.*

**Тэмдэглэлтэй танилцсан:**  
АГААРЫН БОХИРДЛЫГ  
БУУРУУЛАХ АСУУДЛЫН  
ДЭД ХОРООНЫ ДАРГА

Г.ГАНБОЛД

**Тэмдэглэл хөтөлсөн:**  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ  
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ**

2023 оны 06 дугаар сарын 21-ний өдөр,  
Лхагва гараг  
Төрийн ордон “Их эзэн Чингис хаан”  
танхим  
18 цаг 21 минут

### **АГААРЫН БОХИРДЛЫГ БУУРУУЛАХ АСУУДЛЫН ДЭД ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ**

**Г.Ганболд:** Дэд хорооны гишүүдийн төрийн амгаланг айлтгаж байна. Дэд хорооны гишүүдээс Улсын Их Хурлын гишүүн Саранчимэг, Дамдинням, Ганболд нар хүрэлцэн ирсэн. Улсын Их Хурлын гишүүн Туваан, Аубакир нар албан томилолттой байна. Ирц хүрсэн тул Агаарын бохирдлыг бууруулах дэд хорооны 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн ээлжит хуралдаан нээснийг мэдэгдье ээ.

Дэд хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

**Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны төлөвлөгөө болон сайжруулсан түлшний чанар эрсдэлийн талаар цаг үеийн мэдээллийг сонсоно гэсэн ийм төлөвлөгөөтэй байна.**

Хэлэлцэх асуудлын төлөвлөгөөтэй холбогдуулаад асуух асуулт, саналтай гишүүд байна уу. Дамдинням гишүүн. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

**Г.Дамдинням:** Тайлан болон ирэх оных нь төлөвлөгөөг эхлээд сонсчихъё тэгэх үү. Тэгээд нөгөө шахмал түлштэй холбоотой юмыг нь дараа нь сонсоод явчихъя. Тийм л саналтай байгаа юм.

**Г.Ганболд:** Ер нь бид нар ийм юм. Ерөнхийдөө мэдээлэл нь хамт бэлтгэгдсэн. Тийм учраас энэ хүрээндээ

сонсоод, сайжруулсан түлшний асуудал нь нэг их тийм чухал биш. Яг үнэндээ өнөөдрийн байдлаар бол яг сайжруулсан түлшийг Эрчим хүчний яам яг 100 хувь мэдээд, үндэсний хорооноос бол жаахан дэмжлэг л үзүүлж байгаа болохоос биш, шууд хариуцаж байгаа нь Эрдэнэс таван толгой. Тэгээд Таван толгой түлш компаниуд учраас эдний Үндэсний хорооны санхүүжилтээс тэднийд олгож байгаа санхүүжилттэй холбоотой хэсгийг нь л ярих юм. Тийм учраас энэ асуудлаа явъя гэж бодож байна. Хэлэлцэх асуудлынхаа төлөвлөгөөг баталъя.

Мэдээлэлтэй холбогдуулаад ажлын хэсгийг танилцуулъя. Нансалын Тавинбэх Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Энхбат Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга, Ж.Амгаланбаяр Үйл ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн, Б.Оюунчимэг Агаарын чанар хариуцсан ахлах мэргэжилтэн, Э.Ерөөлт Хөрс, ус, хог хаягдлын менежмент хариуцсан ахлах мэргэжилтэн. Насантогтох Эрчим хүчний яамны Эрчим хүчний бодлогын хэрэгжилтийн газрын дарга, И.Лувсанцэрэн мөн яамны Түлшний бодлогын хэрэгжилтийн зохицуулах газрын дарга гэсэн ийм хүмүүс хүрэлцэн ирсэн байна.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 оны үйл ажиллагааны тайлан, 2023 оны төлөвлөгөө болон сайжруулсан шахмал түлшний чанар, эрсдэлийн талаар цаг үеийн мэдээллийг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны Нарийн бичгийн дарга бөгөөд ажлын албаны дарга Энхбат танилцуулна. Ажлын хэсгийн 1 номерын микрофоныг өгье.

**Х.Энхбат:** Агаарын бохирдлын дэд хорооны гишүүд та бүхэндээ Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022 онд хэрэгжүүлсэн ажлын товч

тайлан болон 2023 онд авч хэрэгжүүлэх гэж байгаа арга хэмжээнүүдийн талаар мэдээлэл өгье.

Засгийн газрын 2023 оны 2 сарын 1-ний өдрийн 38 дугаар тогтоолын 7 дугаар хавсралтаар Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг шинэчлэн баталсан. Үндэсний хороо нь 21 хүний бүрэлдэхүүнтэй одоогийн байдлаар ажиллаж байгаа.

Энэ дотроо 6 салбарын сайд, 4 дэд сайд, нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын Их Хурлын дарга, Шадар сайд нарын зөвлөхүүд, мөн төрийн бусад байгууллагуудын удирдлагуудаас бүрдсэн ийм 21 хүний бүрэлдэхүүнтэй байдаг.

Хорооны даргаар эрчим хүчний сайд Чойжилсүрэн, орлогч даргаар Байгаль орчин, аялал жуулчлалын сайд Бат-Эрдэнэ, нарийн бичгийн даргаар Х.Энхбат миний бие ийм бүрэлдэхүүнтэй ажилладаг.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо нь 2022 онд яг төсөвт тусгагдсан хэмжээ нь бол 43,6 тэрбум төгрөгийн төсөвтэйгөөр 49 арга хэмжээг төлөвлөн ажлаа эхлүүлсэн байдаг. Оны төгсгөлд 26 тэрбум төгрөгийн гүйцэтгэлтэй буюу 58,8 хувийн ажлын биелэлттэйгээр ажилласан байдаг.

Өмнөх 2019-2020 онд эхэлсэн боловч дуусаагүй 24 арга хэмжээ бол энэ оны ажлын төлөвлөгөө дээр нэмэгдэж орж ирсэн. Уг он дамжин хэрэгжих төсөл арга хэмжээний гүйцэтгэлийг үнэлж, хөндлөнгийн аудит ажиллуулан дүгнэлт гаргах ажлын хэсгийг Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргын 2023 оны 4 дүгээр тушаалаар байгуулан ажиллаж байгаа.

Ажлын хэсгээс гарсан саналыг Үндэсний хорооны хурлын 2 дугаар хурлаар бол оруулж шийдвэрлэхээр бэлтгэл ажлыг хангаж ажиллаж байгаа. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2023 оны 3 сарын 30-ны өдрийн энэ оны анхдугаар хурлаар бол Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2023 онд хэрэгжүүлэх зарим арга хэмжээг бол баталсан байдаг. /Дэлгэц дээр харагдаж байна./

1 дүгээрт нь бол Улаанбаатар хотын гэр хорооллын 110 мянган айл өрхийг 2,5квт, 20 мянган айлыг 4квт чадалтай цахилгаан халаагуураар халаах техникийн боломж бүрдүүлэх зорилгын хүрээнд 5012 айл өрхийг 4квт чадалтай цахилгаан халаагуур халаах техникийн боломж бүрдүүлэх ийм багц ажлыг бол 15 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэйгөөр баталсан.

2 дугаарт түүхий нүүрсийг хориглох шийдвэрийг хэрэгжүүлэх хүрээнд агаарын чанарыг сайжруулах бүсэд хяналт шалгалт хийх ажилд дэмжлэг үзүүлэх, 459 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажлыг баталсан.

Мөн Эрдэнэс таван толгой ХК эрчим хүчний нүүрсийг баяжуулах туршилт хийх, шахмал түлш болон хагас коксын үйлдвэрүүдтэй танилцаж, бүтээгдэхүүн болон түүхий эдийн туршилт судалгааны ажил хийх ажил дээр 272 сая төгрөг, мөн хорооны уламжлалт ажил болох ногоон зээлийн бүтээгдэхүүн бий болоход дэмжлэг үзүүлэх зээлийн хүүгийн зардалд хөнгөлөлт, татаас олгох ажилд бол 1 тэрбум төгрөг гэсэн ийм үндсэндээ 4 арга хэмжээг бол анхдугаар хурлаараа баталсан. Бусад ажлуудыг бол нэмж судлах шаардлагатай. Он дамжсан ажлууд дээр аудит оруулах шаардлагатай гэсэн Үндэсний хорооны гишүүдийн олонхын саналаар ийм шийдвэр гаргаад Ажлын алба бол аудитын ажлыг, хөндлөнгийн хяналт шалгалтын ажлыг 24 ажил дээрээ

сонсох ажиллагааг гэх мэтчилэн ажлуудыг хийгээд, дүгнэлтээ гаргаад Үндэсний хорооны 2 дугаар хуралд танилцуулахад бэлэн болоод байгаа.

Дээрх төсөл арга хэмжээнүүдээс гадна чиг үүргийн хүрээнд 6 ажлын хэсэг байгуулагдан энэ онд бол ажлаа зохион байгуулаад явж байна. Өмнөх Үндэсний хорооны ажлын албуудаас ялгаатай нь бол энэ он гарснаар шинээр шинэ тутам байгуулагдсан ажлын албаны хувьд бол Засгийн газрын Хэрэг эрхлэх газартай бол маш нягт хамтын ажиллагаатай ажилладаг. Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга Амарбаясгалан даргын тушаалаар “Нийслэлийн хог хаягдлын менежментийг сайжруулах арга хэмжээ менежментийг сайжруулах” ажлын хэсгийг бол байгуулан ажиллаж байгаа. Мөн Амарбаясгалан сайдын тушаалаар ““Эрдэнэт” үйлдвэрийн хог хаягдлын аж ахуйгаас босгодог цагаан тоосны асуудлыг шийдвэрлэх” ажлын хэсгийг байгуулж байгаа. Мөн Амарбаясгалан сайдын тушаалаар “Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны технологийг нь баталгаажуулах, бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрүүдийг судлах” гэсэн ийм 3 үндсэн том ажлын хэсгийг бол Амарбаясгалан сайдын тушаалаар байгуулаад ажиллаж байгаа.

Мөн хорооны дарга болон Эрчим хүчний сайдын тушаалаар Нийслэлийн агаарын бохирдлыг бууруулах сайжруулсан шахмал түлшний чанарыг сайжруулах зорилгоор хагас кокс болон мидлинг баяжуулсан нүүрс, түүхий эдээр шахмал түлш үйлдвэрлэх, туршилт судалгаа хийх, үйлдвэрлэсэн түлшний шинж чанар, агаарын бохирдолд үзүүлэх нөлөөг тодорхойлох гэсэн ажлын хэсгийг байгуулан ажиллаж байна.

Хорооны даргын тушаалаар бол Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны 2022-2023 онд дамжин

хэрэгжиж байгаа ажил, арга хэмжээний гүйцэтгэлийг үнэлэх хөндлөнгийн аудит ажиллуулах ажлын хэсэг гарган ажиллаж байгаа.

Хорооны даргын тушаалаар мөн нийслэл Улаанбаатарын агаарын чанарын бүсэд үйл ажиллагаа явуулж байгаа 100квт-аас дээш хүчин чадалтай уурын зуухуудад бас хяналт шалгалт явуулах, үйл ажиллагааг нь сайжруулах ийм ажлын хэсэг гэсэн ийм чиг үүргийн хүрээнд бол нэлээдгүй ажлын хэсгүүдийг бол байгуулан ажиллаж байна.

Мөн Үндэсний хорооны хувьд бол гадаад харилцаа, олон улсын хамтын ажиллагаа дээр бол нэлээн анхааран ажиллаж байгаа. Энэ хүрээндээ нүүрстөрөгч багатай хөгжлийн түншлэл буюу хамтарсан кредит олгох механизм Японы Байгаль орчны яамтай хамтарч ажиллаж байна. Дэлхийн Эрүүл мэндийн байгууллагатай хамтран Үндэсний хороо дээр агаарын бохирдол бууруулах экспертүүдийг урьж ажиллуулах ажил явагдаж байна. Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамтай хамтраад Америкийн Нэгдсэн Улсын Вашингтоны Их Сургууль болон бусад байгууллагуудаас бас эксперт урьж ажиллуулах ажил явагдаж байна. Мөн Америкийн Нэгдсэн Улсын Элчин сайдын яамны дэмжлэгтэйгээр НАСА-тай холбогдож агаарын чанарыг хиймэл дагуулаас хянах ажил бас явагдаж байна. Нэгдсэн Үндэсний Байгууллагын Хүүхдийн сантай хамтран дулаалгын ажлууд явагдаж байна. ЖАЙКА-гийн Монгол Улс дахь төлөөлөгчийн газартай хамтран Автомашинаас ялгарах хаягдал утааг бууруулах ажлууд хамтарсан ажлын хэсгээр явагдаж байна. ХБНГУ-ын Шенберг гэдэг компанитай хамтран ус цэвэршүүлэх чиглэлээр хамтын ажиллагаанууд явагдаж байна. Монгол Улсын Их Сургууль болон Шинжлэх Ухааны Технологийн Их сургуулиудтай хамтран холбогдох судалгаа шинжилгээний ажлууд явагдаж байгаа. Баярлалаа.

**Г.Ганболд:** Агаарын бохирдлын хорооноос тавьсан мэдээлэлтэй холбогдуулаад асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Дамдинням гишүүнээр тасалъя. Дамдинням гишүүний микрофоныг өгье.

**Г.Дамдинням:** Надад 3 асуулт байна. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны төсөв дээр манай Дархан-Уул аймгийн агаарын бохирдол сүүлийн үед нэлээн их болоод байгаа юм. Улаанбаатар хотод байсан түүхий нүүрс түлдэг нөхцөл байдлаас шалтгаалаад Дархан-Уул аймгийн 15 дугаар баг гэж Хабитат гэдэг газар тэр байшин хорооллынхоо дээр баригдсан. Гэр хорооллуудаар нь ер нь бол утаа ихсээд байгаа. Тэгээд дунд хугацааны шийдэл гээд шахмал түлшний үйлдвэр барих төсөл боловсруулаад, улсын төсөв дээр тусгаад танай хорооны төсөв дээр суугаад явсан. Өнгөрсөн жил. Тэгээд энэ ажил олигтой болсонгүй. Энэ жил та хэд ямар ажил хийх гэж байна. Би бол энэ дээр дахиад саналаа өгөөд л явж байгаа. Энэ дээр та нар ер нь ямар ахиц гаргах вэ. Яах вэ. Би тухайн үед Дархан-Уул аймагт ийм хөрөнгө оруулалт тусчихлаа. Шахмал түлшний үйлдвэр дунд хугацааны шийдлийн хувьд хийгээд явна гээд сонгогчидтой баахан ярьчихсан. Энэ ажил ажил болох ёстой байгаад байдаг. 1 дүгээр асуулт.

2 дугаарт 2020 оны Улсын Их Хурлын сонгуулийн мөрийн хөтөлбөрт аймгийн төвүүдэд хог боловсруулах үйлдвэр барина гэдэг заалт ороод, Монгол Улсыг хөгжүүлэх үндсэн чиглэлд ороод, Засгийн газрын үйл ажиллагааны 4 жилийн төлөвлөгөөнд ороод, хог боловсруулах үйлдвэр аймгийн төвүүдэд хийгдэнэ гэдэг ийм төлөвлөгөө гарчихсан. Энэ төлөвлөгөөний хүрээнд Дархан-Уул аймагт бас тэр хог боловсруулах үйлдвэрийн асуудал яригдах ёстой гэж байнга л хэлж байгаа. Та бүгд онцгой анхаарна, хийнэ гээд байдаг. Энэ дээр ямар ахиц гарч байгаа юм гэдэг 2 дахь асуудал байна.

3 дугаар асуулт би танай тайланг бариад сууж байна. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны мэдээллийг харахад агаарын бохирдлыг бууруулах чиглэлээр, хөрсний бохирдлыг бууруулах чиглэлээр, хог хаягдлыг бууруулах чиглэлээр, усны бохирдлыг бууруулах чиглэлээр гэж тайлан та нар хийсэн ажлаа оруулж ирсэн байна. Дуу чимээний бохирдлыг бас орчны бохирдолд оруулна. Дуу чимээний бохирдол. Өөрөөр хэлбэл зун цаг болж байна. Улаанбаатарчууд энэ улсын нийслэлд нийт хүн амын тал нь амьдарцааж байна. Шөнө орой унтах аргагүй л болж байна л даа бүгдээрээ. Хаа сайгүй дуу чимээ. Бас 11, 12 өнгөрөөгөөд дуусчих юм болов уу гээд хүмүүсийн яриа явж байна. Дуусахгүй байна. Яах вэ, зуны богинохон дулаан улирлуудад болдог юм, бас бизнесийн ашиг байна ард ирээд бас ийм нийгмийн ийм соёлын үйлчилгээ авах ёстой гэдэг талаас нь харахад, нөгөө талд нь хөгшин хүн байна, хүүхдүүд байна. Тэгээд дээрээс нь бас нэг чанга дуутай машинууд байна. Шөнө болохоор энэ хотхонуудын гадна байгаа сул талбай дээр ирээд орилуулаад байна. Чанга дуутай мотоциклууд байна. Энэ бас л нөгөө хүүхэд хөгшидтэй холбоотой л асуудал болох байхгүй юу. Тэгээд машинуудын сигнал байна. Сигналын децибелийн хэмжээ энэ тэр нь ямар байх ёстой юм. Тэгэхээр би ерөнхийдөө энэ хот суурин газрууд, хөдөө орон нутаг, ер нь хүн хамтаараа амьдрах соёлд суралцах ёстой л байхгүй юу. Тэр хамтаараа бид нар амьдрах соёлын хүрээнд дуу чимээний бохирдлыг авч үзэхэд ер нь та нар яаж ажиллаж байна. Хууль эрх зүйн орчин ер нь юу дутуу байна. Шаардлагатай бол та нар Үндэсний хороогоороо дамжуулаад энд ажиллаж байгаа Их Хурлын гишүүдэд бас санал өгөөч. Хуулийн төсөл гаргахад туслаач. Тэгээд яг хийж байгаа юм байвал энэ тал дээр бас эрх зүйн орчных нь тухайд та нар өдий болтол хийж ирж байгаа тухай асуудлыг л тайлбарлаж

өгөөч ээ л гэж хүсье. Ийм 3 асуулт байна.

**Г.Ганболд:** Хэн хариулах вэ. Ажлын хэсгийн Номер.

**Х.Энхбат:** Гишүүний асуултад хариулъя. Үндэсний хорооны хувьд бол ганцхан Улаанбаатар хот гэлтгүй аймаг, орон нутгийнхаа агаарын бохирдолд бол угаасаа санаа тавиад явж байх ёстой. Ерөнхий сайдын захирамжийн дагуу ч гэсэн манай хорооны журам дээр ч гэсэн бас тэгж байдаг. Энэ дагуу бол агаарын бохирдол ихтэй аймгууд дээр нэлээн анхаарал хандуулаад ажлууд бол зохион байгуулж ирж байгаа. Ялангуяа уурын зуухууд дээр бол шүүлтүүр тавих, агаарын автомат харуулын чанарын станц тавих, суурьшуулах, мөн шахмал түлшний үйлдвэрүүд гэсэн ийм ажлууд бол зохион байгуулаад явж байгаа. Дархан-Уул аймгийн хувьд бол шахмал түлшний үйлдвэрийн ажил өнгөрсөн жил эхлүүлэхээр гишүүний санаачилгаар ийм ажил бол эхэлсэн. Үндэсний хорооны хурлаар бол тухайн ажил маань бол санал нь дэмжигдээд, төсөв нь батлагдаад, төсвийг нь аймгийн Засаг даргын Тамгын газар луу бол эрхийг нь шилжүүлээд, аймаг, орон нутаг дээрээ тендер худалдан авах ажиллагаагаа зохион байгуулаад ажлаа гүйцэтгэ гэдэг ийм шийдвэр гараад явсан байдаг. 7 сарын үед бол тендерийн хугацаанд бол эхний тендерийн зарласан хугацаанд бол гүйцэтгэгч компани орж ирээгүй. Мөн тэгээд хугацаа алдаж тендерийн сонгон шалгаруулалт нь явагдахтай зэрэгцээд төсвийн хаах хугацаа болоод тэгээд Сангийн яам дээр бол тухайн төсвийг буцааж татсан ийм байдалтай байгаа. Тэгээд миний бие бас биечлэн Дамдинням гишүүнд нөхцөл байдлын талаар тайлбарлаж хэлж байсан.

Энэ жилийн хувьд бол яг одоогийн байдлаар бол тухайн ажлыг бол үргэлжлүүлэх төлөвлөлт бол арай гараагүй байгаа. Гэхдээ тэрийг бол

нэмж судалж, тодруулаад бол тусгах боломжтой гэж үзэж байна.

Хог боловсруулах үйлдвэрийн хувьд бол нэлээн ая холбогдол өгөөд Үндэсний хорооны хувьд бол явж байгаа. Амарбаясгалан сайдын тушаалаар бол нийслэлийн хог хаягдлын менежментийг сайжруулах хүрээнд хаягдал хогийг дахин боловсруулаад эрчим хүч ялгаруулах ийм технологийн дэвшилтэт төслүүдийг бол нэвтрүүлэхэд ажиллаж байна.

Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба бол яг өөрийнхөө нэр дээр ажлын албаныхаа нэр дээр нийслэлийн хогийн цэгүүдэд хаягдал дахин боловсруулаад эрчим хүч шалгаруулах үйлдвэрийн газруудыг бол ажлын алба дээрээ бол авчихсан. Гүйцэтгэгч компаниудыг бол сонгон шалгаруулаад, Дархан-Уул аймаг дээр бол хэрэгжих боломжтой. Бид нар бол технологийг одоогийн байдлаар бол нэлээн судалж байгаа. 2 төрлийн технологи бол байна.

1 дүгээрт нь бол явуулын буюу шууд тухайн хог хаягдлыг бол өндөр юугаар шатаагаад тэгээд, тухайн төхөөрөмж нь өөрөө шилжээд яваад байдаг ийм төхөөрөмжүүдийг бол бид нар БНХАУ-ын саналаар бол судалчихсан явж байгаа. Нэвтрүүлэх боломжтой гэж харж байгаа.

2 дугаарт нь бол тухайн хаягдлыг дахин боловсруулаад эрчим хүч ялгарах гэсэн ийм үндсэн 2 арга зам байгаа. Тэгэхээр энэ дээр бол Дамдинням гишүүний ажлын албатай хамтраад хамтарсан ажлын хэсэг байгуулаад энэ ажлыг бол яг газар дээр нь очиж судлах ийм юм бодолтой байна.

Дуу чимээний бохирдлын хувьд бол Улаанбаатар хотын захиргаа бол энийг сүүлийн үед нэлээн асуудлыг ярьж эхэлж байгаа. Ер нь бүх бохирдол дээр бол нөгөө стандартын асуудал хамгийн эхлээд гараад, тэгээд стандартад хүрч байна уу, үгүй юу гэдгээсээ шалтгаалж



тухайн ажлууд нь бол төлөвлөгдөөд явдаг байгаа. Тэгэхээр бол стандартаас нь эхлэх ийм шаардлагатай байгаа гэж бол манай ажлын алба дээр бол үзэж байна. Мөн энэ дуу чимээний бохирдлын асуудлыг хөндөж байгаад Дамдинням гишүүнд бол их талархалтай байна. Яг Үндэсний хорооны 5 дахь үндсэн чиглэл болгож оруулах эрх дээр бол дэмжлэг үзүүлж гэдгийг бол талархаж хүлээж авъя. Бид нар бас тэр дээр танд бас саналуудыг бол бичгээр болон биечилж өгөх ийм хүсэлтэй байна.

**Г.Ганболд:** Дамдинням гишүүн тодруулъя.

**Г.Дамдинням:** 2024 оны улсын төсвийн хүрээний мэдэгдэл бид нар батлаад явуулчихсан. Танай төсвийн хүрээг бол ер нь гаргачихсан байгаа байх. Тэгэхээр 2024 оны төсөв дээрээ та бүхэн тэр шахмал түлшний үйлдвэрийг дотооддоо та нар хуваарилалтаа хийдэг. Тэрийгээ саналаа оруулж ирээрэй. Дархан дээр. Өмнө нь хийх гээд болоогүй тэр тендерийн хууль дээр ковидын үед болоогүй юм. Тэрийг бол ойлгож байгаа. Дахиад хийхээс өөр аргагүй. Тэрийг заавал оруулж өгөөч ээ гэж хүсье.

2 дугаарт тэр хог боловсруулах үйлдвэр дээр ч гэсэн ялгаагүй та нар бас Монгол орны 2 дахь том нийслэл, суурьшлын 2 дахь том бүс болгох гээд Засгийн газраас зарлачихсан байгаа энэ хот суурин газрыг анхнаас нь зөв явуулах тал дээр бас анхаарал хандуулж, төсөв дээрээ хуваарилалт хийхийг бодоорой. Би бас бичиг явуулъя.

3 дугаарт тэр дуу чимээний бохирдолтой холбоотой асуудал дээр үнэхээр тэр хууль эрх зүйн орчныг заавал хийх ёстой байгаа шүү. Бүгдээрээ ажиллахгүй бол энэ болохоо байх хэмжээнд хүрч байгаа. Энэ бол соёлт ертөнцөд хот суурин газруудад бол зайлиггүй байдаг зохицуулалт юм байгаа юм шүү. Баярлалаа.

**Г.Ганболд:** Дамдинням гишүүнд баярлалаа. Хэдэн асуулт асууя. Тайлан бол хангалтгүй ирсэн. Тайланг бид нар яаж явуулах вэ гэхээр өнгөрсөн жил яг 43 тэрбумдаа 49 ажил төлөвлөсөн байна. Аль дээр нь хэдэн төгрөг тавьсан нь ерөөсөө тодорхойгүй. Хэдэн төгрөг зарцуулагдсан нь тодорхойгүй. Тэгээд яг хэд нь ямар ажлууд нь хийж дууссан юм, ямар ажлууд нь ямар шалтгаанаар тухайн ондоо хийгдээгүй гэдгийг ерөөсөө гаргаж ирүүлээгүй байгаа байхгүй юу. Өнгөрсөн жил хийж дууссан ажлууд гэдэг дээр ингээд 100 хувь хэрэгжсэн ажлууд гэдэг дээр аймгуудын нам даралтын зууханд утаа шүүгч суурилуулах ажил 100 хувь хийчихсэн гээд байх юм. Тэгээд би бол ойлгож байгаагаар Өвөрхангай эд нар дээр энэ чинь хийгдээгүй шүү дээ. Ямар ч боломжгүй, техникийн шаардлага хангахгүй, түлж байгаа нүүрсээ ерөөсөө судлаагүй ийм шүүлтүүрүүд аваачиж тавиад нөгөөх нь ажиллах боломжгүй байгаа шүү дээ. Тэрийг яах юм. Цаашидаа энэ шаардлага хангаагүй шүүлтүүрүүд тавьсан аж ахуйн нэгжүүдийг яах юм. Гэрээг нь цуцлах юм уу, мөнгийг төлүүлэх юм уу, эсвэл шаардлага хангасан тийм шүүлтүүрийг нь авчиртал нь энэ ажил нь явж байх юм уу гэдгийг би асуух гээд байгаа юм. Ер нь энэ өнгөрсөн жилүүдэд Байгаль орчны яам дээр Үндэсний хорооны дарга байхаараа Байгаль орчны чиглэл рүү баахан юм тавьчихсан. Тэгээд л жорлон гээд л маш олон жижиж юмнууд тавиад энэнээс үр дүн ерөөсөө харагдахгүй байгаа байхгүй юу.

Одоо Эрчим хүчний сайд дээр очсон чинь бүх мөнгөө аваачаад өөрийнхөө салбарын гэр хорооллын дп барих юм байлгүй. 15 тэрбумаар 5 мянган айл өрхийн цахилгаан халаагуур халаах техникийн боломжийг бүрдүүлнэ гэхээр ийм л юм ойлгож байгаа байхгүй юу. Тэгэхээр тэр 5 мянган айл техникийн боломжийг нь бүрдүүлээд эд нар тогийн мөнгө энд орохгүй шүү дээ. Тэгээд салбар яамны ажил хийгээд яваад байх юм бол агаарын бохирдлыг чинь, энэ орчны

бохирдлыг яаж буулгах юм бэ. Өнгөрсөн жил 43 тэрбум төгрөг тавихдаа агаарын бохирдлыг хэдэн хувиар бууруулна гэж төлөвлөж энэ мөнгийг тавьсан юм. Тэр үр дүндээ хүрсэн юм уу. Эсрэгээрээ харин өнгөрсөн жил Улаанбаатар хотод агаарын бохирдол бол асар их байсан. Шалтгаан нь яг юу байсан юм. Сайжруулсан түлшиндээ байсан юм уу. Сайжруулсан түлшинд орж байгаа барьцалдуулагчдаа байсан юм уу. Маш олон хүмүүс угаартаж нас барлаа гээд л эртээд Ардчилсан намын бүлгээс мэдэгдэл хийгээд яваад байсан шүү дээ. Үүний шалтгаан нөхцөлийг Үндэсний хороо дээр тогтоож байгаа зүйл байна уу. Ер нь өнгөрсөн жил угаартай холбоотой, сайжруулсан түлштэй холбоотой ер нь хэчнээн хүн нас барсан юм бэ. Энийг бууруулахад хэдүүлээ ер нь яаж ажиллах юм. Нөгөө нийслэлээс тараагаад байсан нөгөө мэдрэгч дохиолол өгдөг юмнууд нь хэдэн хувь нь ажиллаж байгаа юм. Саяын тэр нас барсан айлуудад тэр нь ажиллахгүй болчихсон байсан юм уу, байсан юм уу. Тэгээд өнгөрсөн жилүүдийнхээ ажлын үр дүнг дүгнэж байж, дараагийнхаа жилүүдийн ажлуудыг төлөвлөж баймаар байгаа байхгүй юу. Тэгэхгүй өнгөрсөн жил бид нар ийм юманд мөнгөө зараад эндээс нь тэдэн хувийн үр дүн гарлаа. Энэ 49 ажлаас орчны бохирдлыг бууруулахад тэдэн хувийн үр дүн үзүүлсэн учраас энэ төслийг нь үргэлжлүүлэе энийг цаашаа үгүй гэдгийгээ ярьж явж байж дараагийнхаа ажлыг төлөвлөж явахгүй бол үр дүн их муутай байна. Тэгээд энэ дээр ямар ч гэсэн би тодорхой хариултууд авъя.

Тэгээд энэ жил 2023 онд 23 юм уу, хэдэн тэрбум юм 26 юм уу тэрбум төгрөг зарцуулах юм байна тийм ээ. Эндээс одоогоор та нар 16,7-г нь ийм юманд зарцуулъя гэсэн байна шүү дээ. Үүний яг үндэслэл шалтгаан нь юу юм. Ингэснээр яг орчны бохирдол хэдэн хувиар буурах юм. 15 тэрбум төгрөгийг яг юунд зарцуулах гэж байгаа юм. Энийг зарцуулснаар яг орчны бохирдол хэдэн

хувиар буурах юм бэ. Одоо байгаа үлдсэн мөнгөнүүдээ яг юунд зарах гэж байгаа юм. Юунд зарахаар төлөвлөж байгаа юм. Өнгөрсөн жилүүдийн 49 ажлаас чинь аль нь үр дүнтэй байсан юм. Тэр үр дүнтэй ямар ажлыг нь үргэлжлүүлэх гэж байгаа юм. Ямар ажлыг нь зогсоох гэж байгаа юм. Энийгээ жоохон тодорхой болгож явахгүй бол энэ Үндэсний хороо гэдэг юм өнгөрсөн жилүүдэд асар их мөнгө зарсан, эцсийн үр дүндээ нийгэмд тухайн 2020-иод оны үед байсан тэр агаарын бохирдлын асуудал 2022 оны өвөл бол эрс нэмэгдсэн шалтгаануудыг тогтоох, тэгээд энийг бууруулах тал дээр тодорхой ажлуудыг төлөвлөсөн зүйл юу байна. Үндэсний хорооноос энийг асууя.

**Х.Энхбат:** Ганболд гишүүний асуултад хариулъя. Засгийн газрын 2 сарын 01-ний тогтоолоор бол Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны дарга, ажлын албаны дарга нар шинэчлэгдэж бүрэлдэхүүн ч гэсэн бас шинэ тутам зохион байгуулагдсан байгаа. Ингээд анхдугаар хурал дээр өнгөрсөн жилд хийгдсэн ажлуудын тайлантай бол Үндэсний хорооны гишүүд танилцаад яг Ганболд гишүүний ярьж байгаа санал дээр бол бүгд олонх дээрээ тогтоод, ер нь өнгөрсөн хугацаанд хийгдсэн бүх ажлуудыг нь эргэж хараадах. Аудит оруул, дүгнэлт гарга гээд ийм чиглэлийг бол ажлын албанд бол өгсөн. Энэ хүрээнд ажлын алба бол Аудитын ерөнхий газар, Авлигатай тэмцэх газар, Засгийн газрын хяналт хэрэгжүүлэх газар гэсэн эрх бүхий газруудтай бол хамтраад идэвхтэй бол ажиллаж байгаа. Аудитын газрын зөвлөмж хүрч ирээд, зөвлөмжийн хэрэгжилтийг хангаад манайх бичиг баримтын бүрдлээс авхуулаад бүх нотлох барим бүгдийг нь цуглуулаад ажлын алба дээр ажиллаж байгаа. Ялангуяа өнгөрсөн жил хийгдсэн 100 хувийн гүйцэтгэлтэй гээд байгаа ажлуудыг бол нэг бүрчлэн бүгдийг нь бол ажлын хэсэг гаргаад явж байгаа. Энэ дотроос бол эхний ээлжид 1 ажил дээр

бол Авлигатай тэмцэх газартай идэвхтэй хамтарч ажилласны үр дүнд бол гэмт хэргийн шинж байдал тогтоогдоод, ингээд прокурор руу шилжээд явж байгаа гэх мэтчилэн эрсдэлүүд байгаа учраас бид бүхэн бол өнгөрсөн жилийн ажлын тайлан дээр өнгөрсөн жил 100 хувь гүйцэтгэлтэй гээд байгаа ажлууд дээр бол нэг бүрчлэн ажиллана. Мөн биечлэн яг газар дээр нь ажиллах ажлууд бас зохион байгуулагдаад эхэлж байна. Энэ 5 дахь өдрөөс эхлээд Эрдэнэт хотоос эхлээд орон нутагт бид нар яг өнгөрсөн жил хийгдсэн, хүлээж авсан гэж байгаа тэр ажлуудыг бол биечилж танилцахаар ажлын хэсэг гарах гээд ажиллаж байгаа.

Мөн өнгөрсөн хугацаанд бол маш их хэмжээний худалдан авалтууд хийгдсэн баланс дээр бүртгэлтэй юмнууд бол байдаг. Тэр болгоныг нь бид нар бас нэг бүрчлэн архивын газартай хамтраад яг балансынхаа дагуу хөрөнгүүд нь байна уу, үгүй юу гэдгийг бол шалгалтын ажиллагаа явуулж байгаа. Энэ бүх ажлуудыг бол дүгнэлтүүдийг нь бид нар 2 дугаар хурал дээрээ танилцуулаад, Үндэсний хорооны 21 гишүүн маань бол цаашидаа хорооны шийдвэр гаргаад явах байх гэсэн ийм бодолтой байна.

Нэмэлт мэдээллийг бол агаарын бохирдол хариуцсан ахлах мэргэжилтэн Оюунчимэг өгнө.

**Г.Ганболд:** 1 номерын микрофоныг өгье.

**Б.Оюунчимэг:** Ганболд гишүүний асуусан асуултаас угаарын хийн мэдрэгчтэй холбоотой асуудал бол 2021 онд ИОТ систем дээр суурилсан угаарын хийн мэдрэгч 63 мянган ширхгийг нийслэл Улаанбаатар хотод суурилуулсан байгаа. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны хөрөнгөөр. 2022 онд 14226-г нийтдээ суурилуулсан. Үүнээс 7626 нь бол Налайх дүүрэгт, 6 аймагт 6600 нь, бусад нь нийслэл Улаанбаатар хотод угаарын хий мэдрэгчүүд 5 толгойн хэрэглэгчийг

үйлчлэх төв дээр хянагдаад сигнал нь ирээд, иргэдэд үйлчлээд явж байгаа. Эндээс бол одоогийн байдлаар яг идэвхтэй ажиллаж байгаа 70625 угаарын хий мэдрэгч байна. Энэ хий мэдрэгчүүдийн ашиглалт явцын дүнгээс харахад бол улирлын чанартай байна. Өвлийн улиралд бол угаарын хий мэдрэгчээ ард иргэд 80 гаруй хувьтай ашигладаг бол яг хавар, намрын улиралд дулаан ороод ирэнгүүт бол 50 хувь хүртэл буурч орж ирдэг иймэрхүү нөхцөл байдалтай явж байгаа. Цаашидаа бол энэ угаарын хий мэдрэгчийг бол нэлээн нэмэгдүүлж сайжруулах ийм шаардлагатай байгаа. Монголд угсардаг үйлдвэрлэдэг компани нь бол Монголд байна. Мөн тэр ИОТ системийн суурин систем, сүлжээ үүсчихсэн байгаа учраас бол энийг бол нэмэгдүүлэх шаардлагатай байгаа юм.

Тэр угаарын хийн хордлогын үйл явдалд хийсэн эрсдэлийн үнэлгээ дүнг бол 2023 оны Монгол Улсын Шадар сайдын 28 дугаар тушаалаар эрсдэлийг үнэлэх, давтан хийх шаардлагатай гэж үзээд 2023 оны 6 сарын 2-ны өдөр 9 байгууллагын 23 хүний бүрэлдэхүүнтэй эрсдэлийн үнэлгээ хийж бүх зөвлөмж Олон улсын байгууллагынх нь зөвлөмжүүд бол гарчихсан байгаа. Энэ 2023 оны 6 сарын 2-ны байдлаар. Энэ тайланг мөн өөрт чинь хүргүүлж болно. Эндээс Дэлхийн Эрүүл мэндийн байгууллага, Эрүүл мэндийн яам, Засгийн газрын түвшинд Нийслэл, дүүргийн Засаг даргын түвшинд ямар ямар ажлуудыг хийж гүйцэтгэх вэ гэдэг зөвлөмжүүдийг мөн өгсөн байгаа. Эрсдэлийн үнэлгээг хийж үзэхэд эрсдэл бол нэлээн өндөр байхаар гэж үнэлэгдсэн байгаа. Дандаа эрсдэлийнхээ үнэлгээ чанар байдлыг хийхдээ асуумжийн аргаар үнэлгээг хийсэн. Хийсэн байна лээ.

**Г.Ганболд:** 1 номерын микрофоныг өгье.

**Б.Оюунчимэг:** Энэ дээр яг нийт тоо нь бол манайд хараахан ирээгүй

байгаа. Нийгмийн Эрүүл мэндийн төвд бол хандчихсан байж байгаа.

**Г.Ганболд:** Ардчилсан намын бүлгийн гишүүд мэдээлэл хийгээд байсан шүү дээ. Ардчилсан намын бүлгийн гишүүд. Тэгээд Үндэсний хороо чинь энийгээ мэдэхгүй сууж байдаг юм уу.

**Х.Энхбат:** Угаарын хийтэй холбоотой асуудал бол бид нар Үндэсний хорооны зүгээс бол сүүлийн жилүүдэд маш онцгой анхаарч, угаарын хий мэдрэгчийн санхүүжилтийн асуудлыг нь шийдвэрлээд, өнгөрсөн жил жишээ нь Налайхад ... угаарын хийнд хордоод хүмүүс бол дуудлага өгөөд, эмчилгээ хийлгээд, хүний амь нас эрсдээд тэр бүх асуудлыг бол Нийгмийн Эрүүл мэндийн төв дээр хариуцаад яг учир шалтгааныг нь тодруулаад яг авч хэрэгжүүлэх шаардлагатай байгаа арга хэмжээг бид нарт ирүүлсний дараа бид нар холбогдох саналуудаа ажлын алба бол Үндэсний Хорооны хуралд оруулаад, тэгээд хурлаас гарсан шийдвэрийг бол албажуулаад явахаар ийм л юутай байгаа.

**Г.Ганболд:** Ерөнхийдөө ойлголоо доо. Ер нь асуултуудад ерөөсөө олигтой хариулсангүй. Үлдэж байгаа мөнгөнүүдээ юунд төлөвлөж байгаа гэж хариулсангүй. Тэр 15 тэрбум төгрөгөөр яг юу хийх гэж байгаа гэж хэлсэнгүй. Ер нь яах гээд байгаа юм. Ер нь яах гэж орж ирсэн юм бэ танай яамныхан ер нь. Тэр 15 тэрбум төгрөгөөр хаана, юу хийх гэж байгаа юм?. Тэрэнд тодорхой хариулт өгөхгүй юм уу. Одоо үлдсэн мөнгөөрөө яг юу хийх гэж байгаа юм хариулт өгөхгүй юм уу. 1 номерын микрофоныг өгье.

**Х.Энхбат:** Орчны бохирдлыг бууруулах үндэсний хороо бол Засгийн газраас баталсан Агаар орчны бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөрийг бол хэрэгжилтийг нь хангаж, салбарын зохицуулалт хийж Засгийн газарт эргээд ажлаа тайлагнаж явдаг ийм журамтай байгаа. Энэ хүрээнд бол Агаар орчны

бохирдлыг бууруулах үндэсний хөтөлбөр дээр бол гэр хорооллын айлуудыг цахилгаан халаагуур хэрэглэх техникийн боломж бүрдүүлэх гээд ингээд энэ ажлыг хий гэдэг. Засгийн газрын тогтоолоор батлагдчихсан ийм ажлын төлөвлөгөө байгаа. Энэ хүрээнд бол шөнийн тариф тэглэх болон цахилгаан халаагуур хэрэглэх техникийн боломж бүрдүүлэх ажил бол ер нь уламжлалт хийгдэж ирж байгаа ийм ажлууд байгаа. Энэ жилийн хувьд бол яг нөгөө агаарын бохирдол маш өндөр нягтаршилтай байдаг Сонгинохайрхан дүүрэг Баянхошууны бүс нутгийг бид нар сонго унгаж аваад, 5 мянган айлыг бол цахилгаан халаагуур хэрэглэх техникийн боломж бүрдүүлэхээр явж байгаа. Энэ нь өөрөө 6 багц ажлаас бүрддэг. Ер нь бол он дамжаад олон жил хийгдээд явж байгаа ийм үр дүнтэй ажил байгаа учраас энэ жил хорооны гишүүдийн маань бол олонхын саналаар дэмжээд, энэ ажлыг бол үргэлжлүүлээд хийгдэхээр болсон байгаа юм.

Төсөв дээр үлдсэн саналыг бол Ажлын алба дээр газруудаас нэгтгээд, саналуудаа аваад л явж байгаа. Ажлын алба бол яг үндэсний хороогоор батлагдсаны дараа яг тухайн төсөв хөрөнгө юунд зарцуулах дээр шийдвэр гарсан бэ гэдгийг л тухайн үед нь л мэдээлэх боломжтой байгаа юм.

**Г.Ганболд:** Ерөнхийдөө мэдээллийг сонслоо. Бас манай гишүүд гадуур хурал давхцаад байгаа учраас гараад яваад байна. Зарим гишүүд албан томилолттой учраас ирц бас жаахан бага байна. Ерөнхийдөө тайланг сонслоо. Өнгөрсөн жилийн гүйцэтгэл бол их муу байгаа юм байна. Үнэхээр хэрэгжүүлье гээд 0 байгаа юмнууд байвал энийг заавал үргэлжлүүлэх шаардлага байхгүй шүү дээ. Миний харж байгаагаар 0 хувийн гүйцэтгэлтэй нэлээн юмнууд байгаа юм байна шүү дээ. Эд нарыхаа шаардлагагүй бол цуцлаад явчих л даа. Цуцлаад ирэх жилийн, энэ жилийнхээ ажлын төлөвлөгөөнд оруулаад явах. Миний

хамгийн гол хэлээд байгаа юм бол өмнөх хийсэн ажлуудынхаа үр дүнг эргээж хараач ээ. Үр дүнгүй байгаа шүү. Одоо ч би энэ жилийн төлөвлөсөн ажлаас бол би үр дүн харахгүй юм байна. Тэгэхээр энэ чинь Үндэсний хороо шүү дээ. Үндэсний хороонд би Байгаль орчны яам нь ч тэр, Эрчим хүчний яам ч тэр, Эрүүл мэндийн яам нь ч тэр, нийслэл Улаанбаатар нь ч тэр бүгдээрээ энэ Үндэсний хороонд харьяалагдаад явж байгаа гэж ойлгоод байгаа шүү дээ.

Үндэсний хороо өөрөө энэ асуудал дээр ач холбогдол өгч, өнгөрсөн өвлийн Улаанбаатар хотын агаарын бохирдол яагаад өнгөрсөн жилүүдээс нэмэгдсэн бэ гэдэг дээр дүгнэлт хий.

Улс төрийн намуудын авчихсан мэдээллийг та нар нягталж, үнэхээр олон хүмүүс угаартаж нас барсан юм уу. Тэрний шалтгаан нөхцөлийг нь тогтоож яаралтай хуралдаач ээ. Нийгэмд үнэн зөв мэдээлэл өгмөөр байна шүү дээ. Улс төрийн намуудын зүгээр гишүүд олоод авчихсан хэвлэлийн хурал хийгээд зарлаад байхад Үндэсний хороо таг. Юу ч байхгүй дуугүй л байгаад байдаг. Дуугүй байж байгаа бол энэ чинь хүлээн зөвшөөрч байгаагийн л 1 хэлбэр шүү дээ. Үгүй ээ, хэрэв үнэхээр тийм олон хүн угаартаад эрсдэлд ороод байгаа бол энийгээ эргээж харах хэрэгтэй байна шүү дээ. Сайжруулсан түли чинь зөв юм уу, буруу юм уу. Тэгээд сайжруулсан түшинээс яг юу нь болохгүй байгаа юм. Миний ойлгож байгаагаар бол дийлэнх барьцалдуулагчаа Хятадаас авчирч байна гэж ойлгоод байгаа шүү дээ. Энийг чинь мэргэжлийн хүмүүсийн бид нарт ярьж байгаагаар шохойн чулуугаар барьцалдуулагч хийчихсэн, үүнээс болоод агаарын бохирдол нэмэгдээд байна гэж хэлээд байна шүү дээ. Энийг судалгаа хийсэн юм байгаа юм уу. Дотооддоо барьцалдуулагчийн үйлдвэр хийх гээд хүмүүс зөндөө яваад байна шүү дээ. Энийг дэмжих боломж бололцоо байгаа юм уу. Бид нар уг нь энэ мөнгийг байна шүү дээ. Хятадаас тэр өндөр үнэтэй

шохойн чулуутай барьцалдуулагч авч ирж байгаа бол эд нар дээр нь дүгнэлтээ гаргаад, дотоодод өөрийн түүхий эдээр барьцалдуулагч хийх боломж гаргаад патентаа авчхаад явж байгаа хүмүүс байх юм бол эд нарт л дэмжлэг үзүүлэх юманд энэ мөнгийг зармаар байгаа байхгүй юу. Хүмүүс дэмжлэг үзүүлэхэд, тэгэхгүй л энд тэндхийн жорлон энэ тэр юманд зараад, энэ чинь хайран, үр дүнгүй байна шүү дээ.

Уг нь энэ чинь Агаарын бохирдлыг бууруулах Үндэсний хороо байсан. Орчны болгоод, баахан юм нэмээд сүүлдээ дуу чимээ гээд л бүр халиад алга болох нь л дээ. Тэгээд юм чинь олон юм руу ороод ирэхээрээ л хэт мөнгө нь жижигдээд, олон юм нь зараад, гарах үр дүн бага байгаад байна. Тэгэхээр Үндэсний хороогоороо та нар нэг яриад, бид нар дахиж энэ дэд хороо дээр бүрэн бүрэлдэхүүнээрээ байж байж ер нь Үндэсний хорооны тайланг сонсоно. Энэ хүрээндээ яг өнгөрсөн өвлийн Улаанбаатар хотын болон бусад газруудын агаарын бохирдолтой холбоотой, сайжруулсан түлштэй холбоотой, сайжруулсан түлшний чанартай холбоотой, барьцалдуулагчтай холбоотой, угаар мэдрэгчтэй холбоотой эрсдэлд ороод олон хүмүүс нас бараад байгаа бол шалтгаан нөхцөлтэй холбоотой мэдээллийг би Үндэсний хорооны даргыг оролцуулж байж, Эрүүл мэндийн сайд, Эрүүл мэндийн дэд сайд ямар хүн байдаг юм. Сайд байгаа юу. Эрүүл мэндийн сайдыг байлгаж байж Байгаль орчны сайд, Нийслэлийн Засаг даргыг байлцуулж, энэ асуудлыг нэлээн өргөн хүрээнд ярьж нийгэмд нэг мэдээлэл өгөхгүй бол их буруу байна. Энийг чинь улс төрийн зорилгоор зарим хүмүүс ашиглаад юм яриад байна. Тэгээд бид нар дээр ноцтой, ноцтой мэдээллүүд байгаа шүү дээ. Урд талаас кокс авчирсан, Хятадаас. Тэрний шинжээчийн дүгнэлт нь гарчихсан л байж байна над дээр. Тэрийг яах юм. Ашиглах юм уу, үгүй юу. Мэдэж байгаа юм байгаа юу тэрийг гэх мэтчилнээр энэ ноцтой асуудал зөндөө

байна. Тэгээд энэ асуудлуудыг ер нь нэг мөр ярьж, шийдэх нь зүйтэй юм байна гэж ингэж бодож байна. Тавинбэх сайд хариулт өгнө.

**Н.Тавинбэх:** Ганболд дарга аа, би манай хүмүүсийн ажлын хэсгийнхний хариулсан хариулт дээр зарим нэг зүйл дээр тодруулга өгөх гэсэн юм. Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны даргаар манай эрчим хүчний сайд томилогдсон нь Эрчим хүчний яам энэ ажлыг бүрэн хариуцна гэсэн үг биш. Энэ тусдаа бүтэц гэдгийг би албан ёсоор хэлье.

Орчны бохирдлыг бууруулах үндэсний хорооны бүрэлдэхүүнийг та мэднэ. Засгийн газрын гишүүд, дэд сайдуудаас бүрдэж байгаа.

Цахилгаан хангамжтай холбоотой нийслэлийн агаарыг бохирдлыг бууруулах чиглэлээр бид нар 4, 5 чиглэлээр ажил хийж байгаа. 1 дүгээрт нь хэрэглэгчийг хангадаг түгээх сүлжээний хүчин чадлыг өргөтгөж, цахилгаанаар халаалтаа шийдэх болон техникийн боломжийг бүрдүүлэх ажлыг хийж байгаа.

2 дугаарт нь бид сэргээгдэх эрчим хүчний эх үүсвэрээр тархмал эх үүсвэр хэрэглэгчид өөрсдөө бий болгож халаалтын асуудлаа шийдэх техникийн боломжийг эрх зүйн орчныг бас бүрдүүлж өгч байгаа.

3 дахь асуудал. Бид нар түлшийг боловсронгуй болгох, түлшийг хөгжүүлэх, түлштэй зэрэгцүүлээд зуухыг хөгжүүлэх, боловсронгуй болгох ажлыг бас хийж байгаа.

5 дахь асуудал бол бид нар газ ахуйн хүрээнд хэрэглэх тал дээр бид нар эрх зүйн орчин болоод хэрэглэгчийн худалдан авах чадварт нийцсэн газ нийлүүлэх тал дээр бас ажиллаж байна гэдгийг хэлье. Тэгээд бусад ажлууд хийгдэж байгаа.

Урт, дунд хугацаанд дунд шатад хэрэгжих төлөвлөгөөний дагуу нийслэлийн эх үүсвэрийн боломжтой зарим дүүргүүдийн цахилгаан халаагуураар халах түгээх сүлжээг өргөтгөх боломжийг бүрдүүлэх зорилгоор түгээх сүлжээг өргөтгөх ажил хийгдээд эхэлчихсэн. Эхний ээлжид бид 2016-2018 онд бид нар 15 мянган айлыг энэ боломжийг хангасан. Дараагийн шатад бид нар энэ жил Үндэсний хороонд саналаа хүргүүлээд, Үндэсний хорооны шийдвэр гарч 5 мянган айлыг цахилгаанаар халаалтаар шийдэх техникийн боломжийг бүрдүүлэх ажлыг хийгээд явж байна. Энэ бол яндангийн тоо цөөрнө л гэсэн үг. Өмнөх ажлуудын үр дүнг авч үзвэл ийм боломж бүрдүүлсэн дүүрэг хороод дээр дунджаар 60 орчим хувь нь цахилгаан халаалтад шийдэж байгаа ийм амжилттай дүн байгаа. Өөрөөр хэлбэл утаа гаргадаг яндангийн тоо 60 хувиар буурч байна гэсэн үг.

Хятадаас түлш импортолсон тухай та ярьж байна. Туршилтын журмаар тодорхой хэмжээний түлш импортолсон. Гэхдээ энийг ахуйн хэрэглээнд хэрэглэгчдэд огт хэрэглээгүй. Зөвхөн үйлдвэрлэлийн хэмжээнд туршилт хийж байгаа. Сайжруулсан шахмал түлшний дотоодын үйлдвэрлэл дээр бид нар барьцалдуулагч, ус, угаасан нүүрсний эрчим хүчний нүүрс ашиглаж байгаа. Угаасан эрчим хүчний нүүрс, сайжруулсан шахмал түлшний нийт орцны 95 орчим хувь байгаа. Барьцалдуулагч 3-5 хувь байгаа. Барьцалдуулагчийг бид нар үндэсний хэмжээнд үйлдвэрлэгч компаниудыг нийлүүлэх боломжтой компаниудын дунд тендер зарласан. Олон сонирхогч байдаг боловч харамсалтай нь үйлдвэрлэл явуулах хэмжээнд хангах ийм нийлүүлэгч бол үндэсний компани бол олдоогүй. 5 компани гэрээ хийсэн. Харамсалтай нь яг өвлийн их ачааллын үеэр гэрээний үүргээ биелүүлж чадаагүйн улмаас цуцалсан байгаа.

Зөвхөн бид нар барьцалдуулагч биш, энэ түлшинд хэрэглэдэг тээвэр, шуудай, барьцалдуулагч гээд бусад зүйл дээр үндэсний компаниудын оролцоог хангах тал дээр идэвхтэй ажиллаж байгаа. Харамсалтай нь шаардлага хангасан үндэсний компаниуд орж ирж чадахгүй байна.

**Г.Ганболд:** 2 номерын микрофон гүйцээж хариулна. 2 номер.

**Н.Тавинбэх:** Түрүүчийн шалгарсан компаниуд бол яг үйлдвэрлэлийн ялангуяа өвлийн их ачааллын үед гэрээний үүргээ биелүүлж чадахгүйн улмаас үйлдвэрлэлд гэр хорооллын хэрэглэгчдийн сайжруулсан шахмал түлшний хангамжид доголдол үүсгэхээр хэмжээнд хүндрэлийг учруулсан. Цаашидаа гэхдээ бид хэдийгээр ийм хүндрэл гарч байгаа ч гэсэн бид нар үндэсний үйлдвэрлэгч нараа сайжруулсан шахмал түлшний түүхий эдийг нийлүүлэх ажил дээр оролцуулах талаар бас ажиллаж байгаа гэдгийг хэлье.

Сайжруулсан шахмал түлшний үйлдвэрлэлд оролцож байгаа энэ зардал нэмүү өртөг болж Монгол Улсад үлдэх нь бол дэмжиж байгаа гэдгийг хэлье. Бодлогоор

Саяын тэр хордсон асуудалтай холбоотой янз бүрийн тоонууд байгаа. Энэ хордоод шууд эрүүл мэндийн байгууллагад ханддаг, хууль хүчний байгууллага руу ишлэждэг. Дараа нь яаманд мэдээлэл ирдэг учраас бидэнд мэдээлэл албан ёсоор бий. Гэхдээ энэ хүний амь нас эрсэдсэн, хордсон, ялангуяа хүний амь нас эрсэдсэн энэ дээр хууль хүчний байгууллагууд шалгагдаж байгаа учраас дэлгэрүүлж мэдээлэл өгөх боломжгүй байна. Бидэнд бас хориглосон. Тийм учраас гишүүнийг шаардлагатай гэвэл бид хууль хүчний байгууллагад хандаад, албан ёсоор зөвшөөрөл аваад, дэлгэрүүлж мэдээлэл өгье. Одоогоор яг ямар шалтгаанаар юунаас болоод ингээд харамсалтай иргэд

амь насаа алдсан ийм хэрэг гарсан гэдэг тодорхой болоогүй байна.

**Г.Ганболд:** Ойлголоо. Ер нь бол Үндэсний хороо ямар нэгэн ийм эрсдэл гарсан тохиолдолд бол яаралтай хуралдаж байх ёстой л доо. Ер нь яаралтай хуралдаж, шалтгаан нөхцөлийг нь тогтоож, нийгэмд зөв мэдээлэл өгч явах нь бол зүйтэй л дээ. Ингээд шалгаж байна гээд дараад, нуугаад байгаа юм шиг байж болохгүй. Ямар нэгэн байдлаар нийгэм дээр сайжруулсан түлшинээс болоод угаартлаа гэх юм бол яаралтай хуралдаад л Үндэсний хорооны зүгээс мэдээллүүдээ аваад тэр мэдээллийг нийгэмд өгч байх ёстой.

Ингээ бид 7 сарын 4-ний үед бид нар бүрэн бүрэлдэхүүнээрээ нэг хурал хийхээр төлөвлөе. Энэ хүрээнд бол бид нар Байгаль орчны сайдыг, Эрүүл мэндийн сайдыг тэгээд Нийслэлийн Засаг дарга, Таван толгой түши компанийн захирлуудыг оролцуулж байж ирэх өвлийг давах, өнгөрсөн өвлийн шалтгаан нөхцөлийн талаар жоохон ярьж явахгүй бол би бол энэ үлдэж байгаа мөнгөнүүдээ бидэнтэй уулзаж байгаа зүгээр дотоодын барьцалдуулагч үйлдвэрлэх гэж байгаа хүмүүсийн хувьд бол санхүүгийн дэмжлэг чухал байгаа байхгүй юу. Тэд нар чинь яагаад нийлүүлж чадахгүй байна гэхээр санхүүгийн дэмжлэг байхгүй учраас л үйлдвэрлэж чадахгүй. Тэгэхээр зэрэг үлдэж байгаа хэдэн төгрөгөө тэр хүмүүст дэмжлэг үзүүлэх чиглэл рүү зарцуулах боломжуудыг бас манай Үндэсний хорооныхон судлах ёстой шүү дээ. Тэр 5, 6 тендерт оролцоод байгаа тэр хүмүүсийг байгууллагууд дээр нь очоод ямархуу хэмжээнд үйлдвэрлэж байгаа юм, ямархуу санхүүгийн дэмжлэг хэрэгтэй байгаа юм. Тэрийг нь эргээд сайжруулсан түлшээр нь төлбөрийг нь барагдуулах хэлбэрээр энэ мөнгө төгрөгийг зарцуулж явах юм бол илүү үр дүнтэй, дотооддоо бас ядаж 5 төгрөг нь үлдэх ийм боломжуудыг л бид нар нээх ёстой л доо. Дотоодод бид нар

*Баянтээгийн уурхай дээр гэхэд дотоодын маш сайн барьцалдуулагч шавраар жоохон улаан буудай хийгээд л барьцалдуулагч хийчихсэн тэр нь лабораторийн шинжилгээгээр хариу нь гарчихсан хэрэглээд л явж л байна л даа.*

*Тэгээд ийм зүйлүүдийг жаахан дэлгэрүүлэх тал дээр санхүүжилтийг нь нэмэх тал дээр Үндэсний хороо жаахан ач холбогдол өгч ирэх жилүүдийнхээ болон энэ жилийн санхүүжилтүүдээ энэ чиглэл рүү зарцуулах нь зөв байх гэж бодож байна. Тэгээд бид нарын хувьд хамгийн гол зорилго бол мэдээж орчны бохирдол бол том нэрээрээ явах нь зөв.*

*Гэхдээ нэн тулгамдаж байгаа, нийгэмд тулгамдаж байгаа асуудал агаарын бохирдлын асуудал байна шүү дээ. Тэгээд энэ чиглэл рүүгээ жаахан түлхүү анхаарч явахгүй бол хэт хөдөө хаа байсан аялал жуулчлал дээр аваачаад л 2 жорлон бариад яваад байх юм бол энэ мөнгө чинь юунд ч хүрэхгүй л дээ. Тэгээд энд бас анхаарч ажиллах ёстой байх гэж бодож байна. Тэгээд бид энэ Их Хурлын Байнгын хороонд хэлээд, ирэх Их Хурлын хуваарьт орчих юм бол та бүхэнд мэдээлэл нь ийм чиглэлээр мэдээлэл сонсьё гэдгийг нь хүргүүлье.*

*Ингээд мэдээлэл өгсөнд баярлалаа.  
Дэд хорооны хурал дууссаныг мэдэгдье.*

*14.59 цаг.*

**Дууны бичлэгээс буулгасан:**  
**ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ**  
**ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ**

**Э.СУВД-ЭРДЭНЭ**